

БАТЛАВ.

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

А.ЭНХМАНЛАЙ

2024 оны 01 дугаар сарын 08-ны өдөр

БАТЛАВ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

2024 оны дугаар сарын-ны өдөр

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 4 СУМЫН ГАЗАР ЗҮЙН НЭРИЙН ТОДРУУЛАЛТ,
МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 01 дүгээр сарын 08

Дугаар 2024-01 Улаанбаатар хот

д/д	Ажлын нэр төрөл	Тайлбар
1.	Ажил гүйцэтгэх үндэслэл	<ul style="list-style-type: none">Монгол Улсын Үндсэн хуульГеодези, зураг зүйн тухай хуульХаягжуулалтын тухай хуульГазрын тухай хуульСоёлын өвийг хамгаалах тухай хуульМонгол хэлний тухай хуульМонгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 186 дугаар зарлигУлсын Их Хурлын 2003 оны 42 дугаар тогтоолМонгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.2.6 дахь заалт“Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийх” ТЭЗҮ.
2.	Ажлын зорилго	Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх
3.	Хамрах хүрээ	Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумын нийт нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэр /УИХ-ын 2003 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан газар зүйн нэр болон бусад газар зүйн нэр/
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	2024 оны дугаар сарын -аас дугаар сарын
5.	Ажлын иж бүрдэл	<p>1. Газар зүйн нэрийн суурин судалгаа хийх</p> <ul style="list-style-type: none">Улсын Их Хурлаар батлагдсан газар зүйн нэрийн судалгаа хийх;Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийсэн 1:100000-ны масштабтай байр зүйн зураг дээрх газар зүйн нэрийг Улсын Их Хурлаар батлагдсан нэртэй харьцуулах;Улсын Их Хурлаар батлагдаагүй газар зүйн нэрийн судалгааг гаргах;Байр зүйн зурагт байршлаараа буруу тэмдэглэгдсэн газар зүйн нэрийн судалгаа гаргах;

		<ul style="list-style-type: none"> • 1:25000-ны масштабтай байр зүйн зураг, хаягийн зураг дээрх газар зүйн нэрийг Улсын Их Хурлаар батлагдсан нэртэй харьцуулах; • Шинээр буй болсон газар зүйн объектууд /Геодези, зураг зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 11.3 заалтыг үндэслэнэ/, тэдгээрийн нэрийн судалгаа хийх. <p>2. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх;</p> <ul style="list-style-type: none"> • Улсын Их Хурлаар батлагдсан нэрийн тодруулалтыг хийх; • Шинээр буй болсон болон устаж үгүй болсон газар зүйн объектууд, тэдгээрийн оноосон нэрийг тодруулах, тогтоох; • Шинээр буй болсон объектын газар зүйн оноосон нэрийн санал боловсруулах; • Газар зүйн нэрийг солбицолжуулах, <p>3. Газар зүйн нэр бүрд хувийн хэрэг үүсгэх;</p> <p>4. Улсын Их Хурлаар батлагдсанаас бусад нэр бүрд /уламжлалт нэр, шинэ нэр/ хүсэлтийн маягт бүрдүүлэх;</p> <p>5. Газар зүйн нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх;</p> <p>6. Газар зүйн нэрийн жагсаалт гаргах;</p> <p>7. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар, сумын газар зүйн нэрийн салбар зөвлөлийн хурлаар тодруулалт хийсэн газар зүйн нэрийн жагсаалтыг, шинэ болон өөрчлөгдсөн нэрийг хэлэлцүүлэх.</p> <p>8. Сумын газар зүйн нэрийн зураг зохиох /1:25000-1:200000-ны масштабтай/, Зураг зүйн зөвлөх инженерээр хянуулах.</p> <p>9. Тайлан бичих, хүлээлгэн өгөх.</p>
6.	Техникийн шаардлага	<p>1. Геодезийн солбицол, өндрийн тогтолцоо, тусгагт хийхдээ:</p> <ul style="list-style-type: none"> • Газар зүйн нэрийн солбицол, өндрийг Засгийн газрын 2022 оны 267 дугаар тогтоолын дагуу тодорхойлох; <p>2. Нэрийн тодруулалт, солбицолжуулалт, хувийн хэрэг, шинэ нэр өгөх болон нэр өөрчлөх санал боловсруулахдаа:</p> <ul style="list-style-type: none"> • “Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг улсын хэмжээнд хийх” ТЭЗҮ-г баримтлах; • Газар нутгийн нэрийн альбом ашиглах; • Монгол газар нутгийн нэрийн зүйлчилсэн толийг ашиглах; • Улсын Их Хурлаар батлагдсан нэрийг өөрчлөхгүй байх; • 1:25000-1:100000-ны масштабтай байр зүйн зураг, мэдээллийн санг ашиглах. <p>3. Нэрийн мэдээллийн сан бүрдүүлэхдээ:</p> <ul style="list-style-type: none"> • ГЗБГЗЗГ-ын даргын 2018 оны А/202 дугаар тушаалаар батлагдсан “Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн загвар”-ыг баримтлах. <p>4. Ашиглах багаж хэрэгсэл, программ хангамж</p> <p><u>Хэмжилтийн багаж, тоног төхөөрөмж</u></p> <ul style="list-style-type: none"> • Жижиг оврын GPS; • Зураг авах камер; • Компьютер;

		<ul style="list-style-type: none"> • Автомашин; <p><u>Боловсруулалтын программ хангамж</u></p> <ul style="list-style-type: none"> • Газар зүйн мэдээллийн сангийн программ хангамж.
7.	Ажлын хяналт, шалгалт	Ажлын гүйцэтгэлд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын газрын даамал хяналт тавина. Ажлын гүйцэтгэлийг шалгаж хүлээн авахад төсөвт өртгийн дүнгээс 6 хувиар тооцно.
8.	Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх	<p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны А/194 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам"-ын дагуу доорх баримт бичиг, тоон мэдээллийг хүлээлгэн өгнө. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан хөмрөгт: <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан /тоон болон хэвлэмэл байдлаар/ - 2% 2. Газар зүйн нэрийн хувийн хэрэг /тоон болон хэвлэмэл байдлаар/ -1% 3. Хүсэлтийн маягт /эх хувь/ - 1% 4. Газар зүйн нэрийн зураг – 2% 5. Гүйцэтгэсэн ажлын тайлан, хувийн хэрэг, хүсэлтийн маягт, газар зүйн нэрийн зураг, мэдээллийн санг тоон байдлаар /*gdb, *doc, *pdf, *jpeg (газар зүйн нэрийн зураг зохиож бэлтгэсэн эх файл layout)/ өргөтгөлтэй/, тухайн газар зүйн нэртэй холбоотой түүх, хүний ярьсан дуу бичлэг, фото зургийг /CD,DVD/ дээр бичих - 2% - Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт: <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан /тоон болон хэвлэмэл байдлаар/ - 1% 2. Газар зүйн нэрийн хувийн хэрэг /тоон болон хэвлэмэл байдлаар/ -1% 3. Хүсэлтийн маягт /хуулбар хувь/ - 1% 4. Газар зүйн нэрийн зураг – 1% 5. Гүйцэтгэсэн ажлын тайлан, хувийн хэрэг, хүсэлтийн маягт, газар зүйн нэрийн зураг, мэдээллийн санг тоон байдлаар /*gdb*doc, *pdf, *jpeg өргөтгөлтэй/, /CD,DVD/ дээр бичих - 2% - Сумын Засаг даргын тамгын газарт: <ol style="list-style-type: none"> 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан /тоон болон хэвлэмэл байдлаар/ - 1% 2. Газар зүйн нэрийн зураг – 1% 3. Гүйцэтгэсэн ажлын тайлан, хүсэлтийн маягт /хуулбар/, газар зүйн нэрийн зураг, мэдээллийн санг тоон байдлаар /*gdb, *pdf, *jpeg өргөтгөлтэй/, /CD,DVD/ дээр бичих - 2% 4. Газар зүйн нэрийн хувийн хэрэг /тоон болон хэвлэмэл байдлаар/ -1%
9.	Захиалагч байгууллага	Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар

10.	Гүйцэтгэгч байгууллага	Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд гүйцэтгэнэ. Ижил төстэй ажил хийж байсан туршлагатай байна.
11.	Санхүүжилт, эх үүсвэр	Дархан-Уул аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт – 82 300 000 төгрөг /Наян хоёр сая гурван зуун мянган төгрөг/
12.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ЗӨВШӨӨРСӨН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



П.БАТСҮХ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.БАТЧУЛУУН

ХЯНАСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д. Мөнхцэцэг

Д.МӨНХЦЭЦЭГ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ГЕОДЕЗИ, ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД
БҮТЦИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г. Энхзаяа

Г.ЭНХЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц. Орлого

Ц.ОРЛОГО

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Г. Нямдорж

Г.НЯМДОРЖ